

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ
МЭЙЖОР ДРИЛЛИНГ МОНГОЛ ХХК-ИЙН
ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХЫН
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА**ОРШИЛ IV****БҮЛЭГ 1. АГУУЛАХЫН ТАНИЛЦУУЛГА..... 1-1**

1.1	КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.2	ТӨСЛИЙН ЗОРИЛГО.....	1-1
1.3	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.3.1	Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг.....	1-1
1.4	ҮНДСЭН БАЙГУУЛАМЖ.....	1-2
1.5	АШИГЛАХ ХИМИЙН БОДИСЫН ТОО ХЭМЖЭЭ.....	1-6
1.6	ДЭД БҮТЭЦ.....	1-9

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2-1

2.1	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-1
2.1.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-1
2.1.2	Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-2
2.1.3	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-3
2.1.4	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-4
2.2	НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-4
2.3	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-6
2.4	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-6
2.5	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-6
2.6	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-11
2.7	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-12
2.8	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	2-13

ДҮГНЭЛТ А**ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ..... В****Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1-1.	Химийн бодисын нэр төрөл, CAS дугаар.....	1-6
Хүснэгт 2-1.	2022 оны БОМТ-ний зардлын хураангуй.....	2-1
Хүснэгт 2-2.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-2
Хүснэгт 2-3.	Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-3
Хүснэгт 2-4.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	2-3
Хүснэгт 2-5.	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-4
Хүснэгт 2-6.	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт.....	2-4
Хүснэгт 2-7.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	2-6
Хүснэгт 2-8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	2-11
Хүснэгт 2-9.	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	2-12
Хүснэгт 2-10.	Дээж авсан цэгийн координат.....	2-15
Хүснэгт 2-11.	Хөрсний химийн шинжилгээний дүн.....	2-15
Хүснэгт 2-12.	Ургамлын бичиглэл хийсэн байршил.....	2-17
Хүснэгт 2-13.	Ургамлын жагсаалт.....	2-17

Зургийн жагсаалт

Зураг 1-1.	Агуулахын байршил.....	1-1
Зураг 1-2.	Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн үндсэн барилга, байгууламж.....	1-2
Зураг 1-3.	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх танхим.....	1-3

Зураг 1-4. Оффисын анхны тусламжийн хайрцаг, аюулгүй ажиллагааны самбар	1-3
Зураг 1-5. Ажилчдын гал тогоо, цайны газар	1-3
Зураг 1-6. Оффис доторх галын булан.....	1-4
Зураг 1-7. Ажилчдын хувцас солих өрөө	1-4
Зураг 1-8. Оффисын гадна байрлах цуглах газар.....	1-4
Зураг 1-9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа.....	1-5
Зураг 1-10. Химийн бодисын сав баглаа боодол	1-5
Зураг 1-11. Химийн бодисын агуулахын агааржуулалт	1-6
ЗУРАГ 1-12. ЗАСВАРЫН ЦЕХ	1-6
Зураг 2-1. Агуулахын агааржуулалтын бүртгэлийн хуудас	2-2
Зураг 2-2. Химийн бодисын ХАЛМ байрлуулсан байдал	2-2
Зураг 2-3. Агуулахад байрлуулсан асгарлтын иж бүрдэл	2-3
Зураг 2-4. Ногоон байгууламж байгуулахын өмнөх дүр зураг	2-5
Зураг 2-5. Ногоон байгууламж байгуулсны дараа	2-5
Зураг 2-6. Шар хуайс.....	2-6
Зураг 2-7. Галын булан байрлуулсан цэгүүд	2-8
Зураг 2-8. Химийн бодисын агуулахын галын булан	2-9
Зураг 2-9. Оффист байрлах галын булан.....	2-9
Зураг 2-10. Галын дадлага, сургалт	2-10
Зураг 2-11. Шалгалтын хуудас.....	2-10
Зураг 2-12. Саармагжуулах хэрэгсэл	2-10
Зураг 2-13. Ажилчдын сургалтын гэрчилгээ	2-11
Зураг 2-14. Хогийн сав.....	2-12
Зураг 2-15. Агуулахын гадна байрлуулсан хогийн сав	2-12
Зураг 2-16. Орчны 50 м зайд цэвэрлэгээ хийж буй байдал	2-12
Зураг 2-17. Агаарын хэмжилт, 10-р сар.....	2-14
Зураг 2-18. Хөрсний дээжлэлт, 10-р сар	2-15
Зураг 2-19. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн	2-16

ОРШИЛ

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь Хан-уул дүүргийн 3-р хороонд байрлах Химийн бодисын агуулахдаа 2022 онд БОННУ-ний нэмэлт тодотгол тайланг байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний Баялаг Эко ХХК-аар хийлгэж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд улмаар 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Тус 2022 оны БОМТ-нд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн энэхүү биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын 4.1-т заасны дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу Баялаг Эко ХХК боловсрууллаа.

.

БҮЛЭГ 1. АГУУЛАХЫН ТАНИЛЦУУЛГА

1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулах
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none"> Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Мэйжор Дриллинг Монгол ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9019012091 Регистрийн дугаар: 2704358 Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ажилчдын гудамж Утас: +976 70119951 +976 99111293 Цахим шуудан: ulzii.chuluuun@majordrilling.com


1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах химийн бодисуудыг тусгай зөвшөөрөл бүхий ханган нийлүүлэгчээс худалдан авч, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах Шинэст ХК-ийн эзэмшлийн химийн бодисын агуулахыг түрээслэн түр хадгалан, цаашид Оюу Толгой ХХК болон бусад захиалагч компаниудын өрөмдлөгийн үйл ажиллагаа явуулахад химийн бодисуудыг хэрэглэнэ.

1.3 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.3.1 Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулах нь Хан-Уул дүүргийн 3-р хороонд үйлдвэрийн бүсэд байрлана. Агуулахын байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Агуулахын байршил

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн барилга нь үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд төслийн барилгын хойд талд Витафит үйлдвэр, урд талд Гоё тараг үйлдвэр, замын эсрэг талд Дулааны 3-р цахилгаан станц, УБЦТС-ын баруун түгээх төв тус тус байрлана.

1.4 ҮНДСЭН БАЙГУУЛАМЖ

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулах нь оффисын барилга болон засварын цех, химийн бодисын агуулах гэсэн үндсэн 3 байгууламжаас бүрдэнэ.



Оффисын барилга



Химийн бодисын агуулах



Засварын цех

Зураг 1-2. Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн үндсэн барилга, байгууламж

Оффис. Оффисын барилга дотор аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг өрөө, ажилчдын гал тогоо, цайны газар, хувцас солих өрөө зэрэг байна. Оффист химийн бодисын агуулахад ажиллах үед ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг тусгай танхим байна.



Зураг 1-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх танхим



Зураг 1-4. Оффисын анхны тусламжийн хайрцаг, аюулгүй ажиллагааны самбар



Ажилчдын цайны газар



Ажилчдын гал тогоо

Зураг 1-5. Ажилчдын гал тогоо, цайны газар



Зураг 1-6. Оффис доторх галын булан



Зураг 1-7. Ажилчдын хувцас солих өрөө



Зураг 1-8. Оффисын гадна байрлах цуглах газар

Химийн бодисын агуулах :

Химийн бодисын агуулахын барилга нь 34.2м² талбайтай, цэвэр бохир ус, дулаан нь төвийн нэгдсэн шугамд холбогдсон, механик агааржуулалттай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, хана, шал нь химийн бодисоос үүссэн тоос, уур манан тогтохооргүй гөлгөр

гадаргуутай, анхааруулах тэмдэг, дохио үг, санамж болон шаардлагатай үед холбоо барих утасны жагсаалтыг ил байршуулсан байна.



Зураг 1-9. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа



Зураг 1-10. Химийн бодисын сав баглаа боодол

Химийн бодисын агуулахын тавиур, бодисын сав баглаа боодол нь Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд (Монгол улсын шадар сайд, байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт) заасан химийн бодисын тавиур нь доорх шаардлагыг хангаж байна. Тухайлбал:

- Химийн бодисын тавиур нь шатамхай биш, химийн бодист тэсвэртэй, бат бөх материалаар хийгдсэн, тогтвортой хөдөлгөөнгүй суурилагдсан
- Тавиур дээр хураасан бодис гулсаж унахаас хамгаалсан хаалттай
- Тавиур нь хэт өргөн биш, хураасан бодис нүдэнд ил харагдахаар, хүрч болохуйц өргөнтэй байна.



Зураг 1-11. Химийн бодисын агуулахын агааржуулалт

ЗАСВАРЫН ЦЕХ



ЗУРАГ 1-12. ЗАСВАРЫН ЦЕХ

1.5 АШИГЛАХ ХИМИЙН БОДИСЫН ТОО ХЭМЖЭЭ

Мэйжор дриллинг монгол ХХК нь олон тооны захиалагч компаниудын хэрэгцээ, шаардлага, стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэн зэс, алт, нүүрс, уран, поташ болон усны өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэх бөгөөд алмазан, чиглэлт, урвуу эргэлтэт, усны болон далд уурхайн өрөмдлөг зэрэг 28 өрмийн машинтайгаар өрөмдлөгийн үйлчилгээг гүйцэтгэдэг байна. Өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах химийн бодисуудын нэршил, CAS дугаар, химийн томъёо, ашиглах тоо хэмжээг Хүснэгт 1-1-д тусгав.

Хүснэгт 1-1. Химийн бодисын нэр төрөл, CAS дугаар

№	Монгол нэр	Олон улсын нэр	Найрлага	CAS дугаар	Хэмжээ (1 жилээр)
				Chemwatch дугаар	
1.	Өрмийн алхны тос	Hammer oil 150	Highly refined paraffinic oil >60%	5500-88	1000 л
2.		Hammer oil 320			1000 л
3.	Өрмийн штангийн тос	Amc liquid rod grease	/CH ₂ -O-C(O)-R1/CH-O-C(O)-R2/CH ₂ -O-C(O)-R3/-	7641-44	2000 л
4.	Өрмийн штангийн тос /өндөр идэвхт/	Amc rod grease xtra tacky	Barium, acetate tallow fatty acid complex hydrocarbon mineral oil (70-80%)	64742-52-5	4000 кг

№	Монгол нэр	Олон улсын нэр	Найрлага	CAS дугаар	Хэмжээ (1 жилээр)
				Chemwatch дугаар	
5.	Өрмийн хошууны тос	Ep bit lube	Refined Vegetable oil /CH ₂ -O-C(O)-R ₁ /CH-O-C(O)-R ₂ /CH ₂ -O-C(O)-R ₃ /-	6921-10-3	4000 л
6.	Ургамлын гаралтай тастагчийн тос	Amc universal		7639-46	5000 л
7.	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Penetrol xtra		7639-46	800 л
8.	Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос	Torque-free xtra		7177-11	800 л
9.	Органик полимер	Austrol	[C ₆ H ₇ O ₂ (OH) ₃ -X(OC ₂ H ₅)X] _n 100% ethylcellulose	9004-57-3	5000 кг
10.	Шингэн полимер	Amc-liquid pol	Drilling fluid additive	60815	5000 кг
11.	Сэргээх полимер	Amc-cr-650	Drilling fluid additive, 100%	4902-92	5000 кг
12.	Полимер, өсдөг	Amc-aus plug	Cross-linked polyacrylamide, 100%	9003-05-8	2000 кг
13.	Нийлэг ко-полимер	Aus-floc	Co-Polymer	4902-93	800 л
14.		Aus-floc blocks		6089-06	768 кг
15.	Цэвэрлэгч полимер	Well clean	Sodium carboxymethyl cellulose, 100%	7758-16-9	480 кг
16.	Полимер, цавуулаг	Amc pac-l	Sodium carboxymethyl cellulose, 100%	9004-32-4	768 кг
17.		Amc pac-r			3000 кг
18.		Ezee pac-r			3000 кг
19.	Өрөмдлөгийн цемент	Gyp-set 15	Calcium sulfate hemihydrate	10034-76-1	2000 кг
20.		Gyp-set 30			2000 кг
21.	Шингэн цемент	Fr-100l	Naphthalenesulfonic acids	68153-01-5	800 л
22.	Цементийн нэмэлт	Amc xxx 10	Calcium chloride 80%	10043-52-4	320 кг
23.		Amc xxx 15	fly ash-low quartz 20%	68131-74-8	480 кг
24.	Өрөмдлөгийн хөөс	Super foam	Anionic surfactants, 60%	7177-08	800 л
25.	Өрөмдлөгийн нийлэг хөөс	Aus grip a eco	Polyethylene/polypropylene/glycol glyceryl ether	9082-00-2	548.1 кг
26.		Aus grip b eco	Polymeric diphenylmethane diisocyanate	9016-87-9	81.9 кг
27.	Өрөмдлөгийн тэнцвэржүүлэгч	Amc ground stabilizer	Vinyl acetate homopolymer 30-60%	9003-20-7	800 л
28.	Өрөмдлөгийн хагарал тогтоогч	Fracseal	Micronised organic cellulose fiber, 100%	9004-34-6	875 л
29.	Өрмийн угаалгын шингэн	Amc truck wash	Detergent blend, 100 %	7639-45	800 л
30.	Концентратат цэвэрлэгч бодис	Amc aus det xtra	Nonhazardous ingredients, 60	7732-18-5	800 л
31.	Ус ангижруулагч	Soda ash	Sodium carbonate, 99%	497-19-8	1000 кг
32.	Кальцийн хлорид	Calcium chloride	Calcium chloride, 85%	10043-52-4	1000 кг
33.	Газрын давс	Potassium chloride	Potassium chloride, 99% KCL	7447-40-7	1050 кг
		Amc klatrol			

№	Монгол нэр	Олон улсын нэр	Найрлага	CAS дугаар	Хэмжээ (1 жилээр)
				Chemwatch дугаар	
34.	Өрөмдлөгийн ус ангижруулагч	Amc water conditioner	EDTA tetrasodium salt 75%, sodium carbonate 25%	64-02-8 497-19-8	480 кг
35.	Хүндрүүлэгч материал	Barite	Barium sulfate	7727-43-7	1200 кг
36.	Ус алдалт тогтоогч	Shur seal	Shredded paper	42071	200 кг
37.	Филтрекс	Filtrex		9003-20-7	2000 кг
НЭМЭГДЭЖ БУЙ БОДИСУУД					
1.	Өрмийн шингэн найруулагч	Ausgel	NA	NA	2000 кг
2.	Супер Поли, Өрөмдлөгийн полимер	Super Poly	Акрилаци кополимер 30-40 %, усны аргаар боловсруулсан хөнгөн нефтийн нэрмэл бодис 10-30 %, ус 30-70%	-	2 тн
3.	Өрмийн шавар	Super Gel	Bentonite (organic clay) 60-100 %	1302-78-9	2 тн
		Sinomud CX Ben			
4.	Өрмийн товуд	Rod Grease		9003-29-6	2 тн
5.	ПЛАГ	Plug		9003-004-7	2 тн
6.	Өрмийн тос /усан суурьт дрилл люб/	Drill Lube	Өөх тосны хүчлийн эфир 70-100 %, ус 5- 30 %	91050-89-4	2 тн
7.	Целлюлоз	CX-Troll	Polysaccharide 60-100 %	9004-34-6	2 тн
	Полисахарид	VIS			
8.	Анионик полимер	CHP Plus	Акрилат кополимер 90-95 %	25035-69-2	2 тн
9.	Ургамлын гаралтай уусдаг тос	SUPERLUBE	Triethanolamine <1, sodium sulfate <5	NA	5 тн
10.	Тос	AMC Thread Grease-DRTG	NA	NA	5 тн
11.	Усан суурьтай өрөмдлөгийн шингэнд хэрэглэх зориулалттай силикон суурьтай бүх төрлийн хөөс арилгагч	AUS Defoamer S	Аюултай биш бодис, 100%	26-5533	1 тн
12.	Өндөр чанарын занарын урвал саармагжуулах	Sinomud Kla- stab	Полиамин	9046-10-0	1 тн
13.	Хүхрийн хүчлийн давс	Sodium Sulphite	Sodium Sulphite >95	7757-83-7	1 тн
		Sodium Sulfate Anhydrous			
14.	Өрөмдлөгийн шингэн нэмэлт	AMC Glute 9	Глутаральдегид 50%, ус 50%	111-30-8 50%	1 тн
		AMC Glute 50		7732-18-5 50%	
15.	Магнийн оксид	Mangnesium Oxide	Магнийн оксид >65 %, кальцийн оксид 1-3 %, үлдсэн аюулгүй найрлага	-	1 тн
16.	Нимбэгийн хүчил	Citric Acid	Citric acid > -96	77-92-9	1 тн

№	Монгол нэр	Олон улсын нэр	Найрлага	CAS дугаар	Хэмжээ (1 жилээр)
				Chemwatch дугаар	
17.	Органик полимер	AMC Ezee trol	Sodium carboxymethyl cellulose (>60%); sodium carbonate (<5%)	-	1 тн
18.	Ксантан хүнсний өтгөрүүлэгч	Sino mud Poly XCD	Ксантан бохь 60-90 %	11138-66-2	1 тн
		AMC Xanbore	Ксантан бохь 100%		
19.	Өрөмдлөгийн нэмэлт шингэн	AMC Quick Seal	Найрлагыг аюулгүй гэж тодорхойлсон, 100 %	62-2620	1 тн
20.	Өрөмдлөгийн шингэний нэгдэл. Viscosifier.	AMC Ben	Bentonite, >94 %	1302-78-9	1 тн
21.	Цардуул	AMC Aus Dex	Холимог >60	9005-25-8	1 тн
22.	Биоцид	AMC Biocide G	Tetrakis (hydroxymethyl) phos[honium sulfate <25, ingredients determined not to be hazardous >60	55566-30-08	1 тн
23.	Цемент түргэн хатаагч, үсгүйжүүлэгч нэмэлт	BASF MasterRheobuild 1000 NT	Calcium naphthalene sulphonate formaldehyde condensate (25 - 50%); нэмэлт(үүд) (үлдсэн)	37293-74-6	1 тн
24.	Содын бикарбонат	AMC Sodium bicarbonate	Sodium bicarbonate >99	144-55-5	1 тн
25.	Seal лац	Sinomud Seal	Шааран ноосон эслэг 60-100 %	65996-69-2	1 тн

1.6 ДЭД БҮТЭЦ

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн барилга нь цэвэр бохир ус, дулаан зэрэг нь төвийн нэгдсэн шугамд бүрэн холбогдсон.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан байдаг.

Нөгөө талаас төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын 2022 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 11,958,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2-1. 2022 оны БОМТ-ний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	983,000.00
2.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	1,035,000.00
3.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,100,000.00
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,240,000.00
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	5,200,000.00
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,400,000.00
Нийт зардал		11,958,000

2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь төслийн БОННУ тайланд тусгаснаар:

- Агуулахын дотоод агаарын чанар муудах
- Химийн бодисын буруу хадгалалтаас үүдэн химийн бодис алдагдах агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, галын аюул гарах зэрэг нөлөөлөл байна.

2022 оны БОМТ-нд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд агуулахын агааржуулалтын системийг тогтмол шалгах, химийн бодисын сав баглаа бүр дээр

ХАЛМ-ын дагуу тэмдэг тэмдэглэгээ байрлуулах зэрэг ажлыг хийхэд нийт 983,000 төгрөг төсөвлөсөн байна.

- Агуулахын агааржуулалтын системийг өдөр бүр шалгаж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тухай бүрт засварлах /Өдөр бүр хяналтын хуудас бөглөх/
- Химийн бодисын сав баглаа бүр дээр ХАЛМ-н дагуу тэмдэг тэмдэглэгээ, тайлбарыг тавих

Эдгээр ажлуудын биелэлтийг Хүснэгт 2-2-д тусгав.

Хүснэгт 2-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Агуулахын агааржуулалтын системийг өдөр бүр шалгаж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тухай бүрт засварлах /Өдөр бүр хяналтын хуудас бөглөх/	Өдөр бүр агуулахын агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагааг шалгаж, бүртгэлийн хуудас хөтөлдөг.	100 %
2.	Химийн бодисын сав баглаа бүр дээр ХАЛМ-н дагуу тэмдэг тэмдэглэгээ, тайлбарыг тавих	Агуулахад хадгалдаг нийт 62 бодис тус бүрийг ХАЛМ-ын дагуу тэмдэг тэмдэглэгээ нааж, зориулалтын тавиурт хадгалдаг.	100 %

Сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны биелэлтийн холбогдох зураг, баримтыг доор тусгав.

№	Химийн бодисын агуулах шалгах ХУУДАС						Сэтгүүл Тайлбар
	Агааржуулалт	Өдөр бүр	Тас дараагаар	Эвдрэл гэмтэл	Тусламж	Угсралт	
1	✓	✓	✓	✓	✓	✓	
2	✓	✓	✓	✓	✓	✓	
3	✓	✓	✓	✓	✓	✓	
4	✓	✓	✓	✓	✓	✓	
5	✓	✓	✓	✓	✓	✓	
6	✓	✓	✓	✓	✓	✓	
7	✓	✓	✓	✓	✓	✓	
8	✓	✓	✓	✓	✓	✓	
9	✓	✓	✓	✓	✓	✓	
10	✓	✓	✓	✓	✓	✓	
11	✓	✓	✓	✓	✓	✓	
12	✓	✓	✓	✓	✓	✓	
13	✓	✓	✓	✓	✓	✓	
14	✓	✓	✓	✓	✓	✓	
15	✓	✓	✓	✓	✓	✓	
16	✓	✓	✓	✓	✓	✓	
17	✓	✓	✓	✓	✓	✓	
18	✓	✓	✓	✓	✓	✓	
19	✓	✓	✓	✓	✓	✓	
20	✓	✓	✓	✓	✓	✓	
21	✓	✓	✓	✓	✓	✓	
22	✓	✓	✓	✓	✓	✓	
23	✓	✓	✓	✓	✓	✓	
24	✓	✓	✓	✓	✓	✓	
25	✓	✓	✓	✓	✓	✓	
26	✓	✓	✓	✓	✓	✓	
27	✓	✓	✓	✓	✓	✓	
28	✓	✓	✓	✓	✓	✓	
29	✓	✓	✓	✓	✓	✓	
30	✓	✓	✓	✓	✓	✓	
31	✓	✓	✓	✓	✓	✓	

Зураг 2-1. Агуулахын агааржуулалтын бүртгэлийн хуудас



Зураг 2-2. Химийн бодисын ХАЛМ байрлуулсан байдал

2.1.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн БОННУ тайланд тусгаснаар химийн бодисын сав баглаа боодолд үлдсэн бодис асгарч хөрс бохирдож болзошгүй байна.

2022 оны БОМТ-нд хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд химийн бодисын сав баглаа боодлыг буцааж хүлээлгэн өгөх ажлыг төлөвлөсөн байна.

Химийн бодисын сав баглаа боодлыг буцааж хүлээлгэн өгөх ажлын биелэлтийг Хүснэгт 2-3-д тусгав.

Хүснэгт 2-3. Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.		Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай 2022.09.27 өдөр №18/-3/26 тоот Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээтэй бөгөөд гэрээний дагуу сар бүр тээвэрлүүлдэг.	100 %
2.	Химийн бодисын сав баглаа боодлыг буцааж хүлээлгэн өгөх	Харин аюултай хог хаягдлыг Цэцүүх Трейд ХХК-тай 2022.03.02 өдөр байгуулсан Т-22/017, III-22/033 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх болон, тээвэрлэлтийн гэрээтэй. Гэрээний дагуу 400 кг хуванцар, 350 кг шуудайны химийн бодисын хаягдлыг 2022.10.27 өдөр № 00377 дагалдах бичгээр хүлээлгэн өгч, устгуулсан.	100 %

Энгийн болон аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах гэрээг ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ болон Цэцүүх Трейд ХХК нартай тус тус байгуулсан бөгөөд хавсралтаар гэрээнүүд, төлбөрийн баримт болон хүлээлцсэн актуудыг оруулав.

2.1.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын 2022 оны БОМТ-нд усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх асгаралтын иж бүрдлийг байрлуулах ажлыг төлөвлөсөн байна.

Химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх асгаралтын иж бүрдлийг байрлуулах ажлын биелэлтийг Хүснэгт 2-4-д тусгав.

Хүснэгт 2-4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх асгаралтын иж бүрдлийг байрлуулах	Химийн бодисын агуулахын үүдэнд асгаралтаас сэргийлэх хэрэгслийг байрлуулсан.	100 %



Зураг 2-3. Агуулахад байрлуулсан асгаралтын иж бүрдэл

2.1.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын 2022 оны БОМТ-нд ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд агуулахын талбайн 10 хувиас багагүй талбайд мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар ногоон байгууламжийг байгуулах ажлыг төлөвлөсөн байна.

Энэ ажлын биелэлтийг Хүснэгт 2-5-д тусгав.

Хүснэгт 2-5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар ногоон байгууламжийг байгуулах	7 дугаар сард хашааны гадна талд авто замын хажуугийн 0.3 км газарт мэргэжлийн Айвико ХХК-иар ногоон байгууламжийн ажлыг хийлгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн “Ногоон байгууламжийн төлөвлөгөө”-ний хэсэгт тусгав.	100 %

2.2 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын төслийн БОННУ тайланд төслийн талбайн 10 хувиас багагүй талбайд мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар ногоон байгууламжийг байгуулах ажлыг хийж гүйцэтгэхийг тусгасан байна.

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь 2022 оны 7 дугаар сард цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн мэргэжлийн Айвико ХХК-иар ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн.


Хүснэгт 2-6. Ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар ногоон байгууламжийг байгуулах	7 дугаар сард хашааны гадна талд авто замын хажуугийн 0.3 км газарт мэргэжлийн Айвико ХХК-иар 150 ш Шар хуяйс тариулж, арчилгаа тордолгоог хийж байна.	100 %

Ногоон байгууламж байгуулахын өмнө Зураг 2-4-т тусгасан газар байсан.

Analysis

1. Одоогийн байдал / Site



View



View



View



Lead

Зураг 2-4. Ногоон байгууламж байгуулахын өмнөх дүр зураг

Ногоон байгууламж байгуулсны дараах байдлыг Зураг 2-5-т тусгав.



Зураг 2-5. Ногоон байгууламж байгуулсны дараа

Талбайн бохирдсон хөрсийг бүрэн сольж тохиромжтой хөрсийг суулган мод тарьсан.



Зураг 2-6. Шар хуайс

Ногоон байгууламжийн ажилд нийт 4 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс 2 сая төгрөгөөр мод тарьж, 1.5 сая төгрөгөөр хайс хамгаалалт барьж, 500,000 төгрөгийг усалгааны төхөөрөмж худалдаж авахад зарцуулсан байна.

2.3 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөөгүй болно.

2.4 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд түүх, соёлын өвд нөлөөлөл байхгүй учир хамгаалах арга хэмжээг төлөвлөөгүй болно.

2.5 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын үйл ажиллагаанаас осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь төслийн БОННУ тайланд тусгаснаар:

- Гал түймэр
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаагүйгээс осол, аюул гарах
- Химийн бодисын асгаралт 20л-250л хүртэл асгарсан тохиолдолд асгаралтын иж бүрдэл хэрэглээгүй улмаас химийн бодис тархах зэрэг нөлөөлөл байна.

2022 оны БОМТ-нд осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлэх, ажилчдад сургалт зохион байгуулах, химийн бодис асгарах, алдагдах үед хэрэглэх саармагжуулах хэрэгслийг байрлуулах зэрэг ажлыг хийхэд, 2,100,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Энэ ажлын биелэлтийг Хүснэгт 2-7-д тусгав.

Хүснэгт 2-7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах. Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган	Химийн бодисын агуулах болон оффис тус бүрт галын булантай бөгөөд галын иж бүрдлийг байрлуулсан.	100 %

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
	ажиллагсдад сургалт зохион байгуулах	Ажилчдад улирал бүр тогтмол галаас хамгаалах, гал гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж, шалгалт авч чадавхыг бэхжүүлдэг бөгөөд сургалтад хамрагдсан ажилтан бүр гэрчилгээ авдаг. Мөн химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.	
2.	Химийн бодистой харьцах болон үйлдвэрийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа, сургалт хийх	МКЛ сургалтын төвтэй хамтарч химийн бодис аюулгүй ажиллагаа сургалтыг тогтмол зохион байгуулсан бөгөөд 100 гаруй ажилтан хамруулсан байна.	100 %
3.	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг байрлуулах, бэлтгэх	Агуулахад химийн бодис асгарах үед саармагжуулах хэрэгслийн иж бүрдлийг байрлуулсан.	100 %

Мэйжор Дриллинг ХХК нь 2022.05.29 өдөр Хан-Уул дүүргийн Онцгой байдлын газраар шалгалт хийлгэн, № 1921619 тоот галын дүгнэлтийг гаргуулсан.

Галын булан байрлах цэгүүд, галын булан, сургалт, шалгалтын хуудас зэргийн зургуудыг Зураг 2-8, Зураг 2-9, Зураг 2-10, Зураг 2-11, Зураг 2-11-т саармагжуулах хэрэгслийг Зураг 2-12-т тусгав.



Зураг 2-7. Галын булан байрлуулсан цэгүүд



Зураг 2-8. Химийн бодисын агуулахын галын булан



Зураг 2-9. Оффист байрлах галын булан



Зураг 2-13. Ажилчдын сургалтын гэрчилгээ

2.6 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Химийн бодисын агуулахын 2022 оны БОМТ-нд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд ахуйн хог хаягдлыг ангилан эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлэх, химийн бодис ачиж буулгах түр ажилчдад зориулан агуулахын гадна талд хогийн сав байрлуулах, аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх зэрэг ажлуудыг хийхээр 1,240,000 төгрөг төсөвлөсөн байна.

Энэ ажлын биелэлтийг Хүснэгт 2-8-д тусгав.

Хүснэгт 2-8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Хог хаягдлыг ангилан ялгаж аль болох богино хугацаанд төслийн талбайгаас тогтмол зайлуулж байх, орчны 50 м зайд цэвэрлэгээ хийх	<ul style="list-style-type: none"> Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай 2022.09.27 өдөр №18/-3/26 тоот Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээтэй бөгөөд гэрээний дагуу сар бүр тээвэрлүүлдэг. Дахин боловсруулах боломжтой хуванцар сав болон цаасыг тусад нь цуглуулж ТҮК-ийн жолоочид тусад нь өгдөг. Орчны 50 м зайд цэвэрлэгээ хийдэг 	100 %
2.	Химийн бодис ачиж буулгах түр ажилчдад зориулан агуулахын гадна талд хогийн сав байрлуулах	Агуулахын гадна цаас, хуванцар болон энгийн хог хаягдал гэсэн 3 төрлөөр ангилан ялгах хогийн савыг байрлуулсан.	100 %
3.	Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарсан тохиолдолд аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь түр хадгалан тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх	Аюултай хог хаягдлыг Цэцүүх Трейд ХХК-тай 2022.03.02 өдөр байгуулсан Т-22/017, III-22/033 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх болон, тээвэрлэлтийн гэрээтэй. Гэрээний дагуу 400 кг хуванцар, 350 кг шуудайны химийн бодисын хаягдлыг 2022.10.27 өдөр № 00377 дагалдах бичгээр хүлээлгэн өгч, устгуулсан. /дагалдах бичиг болон гэрээг хавсаргав./	100 %
4.	Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь түр хадгалахдаа тусгайлсан талбай бэлдэж, ангилан ялгах	Оффист ангилан ялгалттай хогийн савыг 6 ш байрлуулсан.	100 %



Зураг 2-14. Хогийн сав



Зураг 2-15. Агуулахын гадна байрлуулсан хогийн сав



Зураг 2-16. Орчны 50 м зайд цэвэрлэгээ хийж буй байдал

2.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн Химийн бодисын агуулахын 2022 оны БОМТ-нд удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд гэнэтийн ослоос сэргийлэх талаар ажилчдад сургалт зохион байгуулах, химийн бодисын зөвшөөрөл сунгах, аудит хийлгэх зэрэг ажлыг төлөвлөсөн байна.

Энэ ажлын биелэлтийг Хүснэгт 2-9-д тусгав.

Хүснэгт 2-9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Агуулахад гэнэтийн осол аваар , гал түймэр, үер усны аюул гэх мэтийн гэнэтийн ослоос	<ul style="list-style-type: none"> МКЛ сургалтын төвтэй хамтарч химийн бодис аюулгүй ажиллагаа сургалтыг зохион байгуулсан бөгөөд 	100 %

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
	урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	100 гаруй ажилтан хамруулсан байна. • Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтантай хамтран ажилчдад Галын аюулгүй байдлын дадлага сургалтыг 15 хүнд зохион байгуулсан.	
2.	Химийн бодис импортлох ашиглах зөвшөөрөл сунгах	2022.04.04 өдөр сунгаж, 0002148 дугаар зөвшөөрөл авсан.	100 %
3.	Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх, аюулгүй ажиллагааны болон аваар ослоос урьдчилан сэргийлэх, гамшгаас сэргийлэх, сургалтыг зохион байгуулах	Ажилчдад улирал бүр сургалт зохион байгуулж, дадлагажуулдаг. Нийт 100 гаруй ажилтан сургалтад хамрагдаж, сертификат авсан.	100 %
4.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 101 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх	Энвайроментал Комплайнц ХХК-иар аудитыг 2022.02.10 өдөр хийлгэсэн бөгөөд аудитын дүгнэлтэд зааснаар БОМТ-г батлуулан мөрдөж ажиллах, биелэлтийг тайлагнах, , агуулахын агаарын чанарын дотоод хяналт хийх, Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөөг Хан-уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээр батлуулсан гэх мэт авч хэрэгжүүлэх ажлуудыг 2022 онд хийж гүйцэтгэсэн. 2024 онд дараагийн аудитыг хийлгэхээр төлөвлөж байна. /аудитын дүгнэлт болон химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөөг хавсаргав/	100 %

2.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Химийн бодисын агуулахын 2022 оны БОМТ-нд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарт орчны тоосжилт болон, бохирдуулагч хийн хэмжээг тодорхойлуулах, хөрсөн бүрхэвчид хөрсний ерөнхий болон хүнд металлын үзүүлэлтийг шинжлүүлэх, ургамлан нөмрөгт мониторинг хийлгэх зэрэг ажлуудыг төлөвлөсөн байна. Хяналт, шинжилгээний ажлуудыг төлөвлөсөн хуваарийн дагуу Баялаг Эко ХХК хийж гүйцэтгэн, магадлан итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлсэн хариуг тайланд хавсаргав.

Энэ ажлын биелэлтийг доорх хүснэгтэд тусгав.

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Агаарт орчны тоосжилт (PM2.5, PM10 TSP) болон агаар бохирдуулагч хий (SO ₂ , NO ₂ ,) тодорхойлуулах	2022.10.28-ний өдөр Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораториор хэмжилт хийлгэсэн.	100 %
2.	Хөрсөн бүрхэвчид ерөнхий үзүүлэлт болон хүнд металлыг тодорхойлуулах	2022 оны10 дугаар сард хөрсний дээж авч, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хөрсний лабораториор хөрсний ерөнхий химийн шинжилгээ, хөрсний хүнд металлын шинжилгээг Эс Жи Эс ХХК-ийн лабораториор тус тус шинжлүүлсэн.	100 %

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
3.	Ургамлын мониторинг хийлгэх	Баялаг Эко ХХК-ийн мэргэжилтэн агуулахын талбайд ургамлын мониторинг хийсэн.	100 %

Агаарын чанар. Хэмжилтийн үр дүнгээр агаар дахь нийт тоос, хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж MNS:4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын 20 минутын хэмжилтийн хүлцэх агууламжаас даваагүй байна.



Зураг 2-17. Агаарын хэмжилт, 10-р сар

Хэмжилтийг График 2-1, График 2-2, График 2-3-т тусгав.




График 2-1. Хүхэрлэг хийн 20 минутын хэмжилтийн дүн



График 2-2. Азотын давхар ислийн 20 минутын хэмжилтийн дүн




График 2-3. Нийт тоосны 20 минутын хэмжилтийн дүн

Хөрсөн бүрхэвч. Химийн бодисын агуулахын ойр орчмоос авсан хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, бага зэрэг карбонаттай, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр, хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд байна.

Хөрсний дээж авсан цэгийн координатыг Хүснэгт 2-10-д, дээжлэлт хийх явцыг Зураг 2-18-т, химийн шинжилгээний дүнг Хүснэгт 2-11-д тусгав.



Зураг 2-18. Хөрсний дээжлэлт, 10-р сар


Хүснэгт 2-10. Дээж авсан цэгийн координат

№	Байршил	Өргөрөг	Уртраг
1.	Оффисын хажуу	47°53'48.3''	106°52.2'24.6''
2.	Агуулахын гадна	47°53'50.3''	106°52'19.6''

Хүснэгт 2-11. Хөрсний химийн шинжилгээний дүн

№	pH	ЦДЧ,dsm	Ялзмаг, %	CaCO ₃ , %	Хөдөлгөөнт элементүүд, мг/100 г	
					P ₂ O ₅	K ₂ O
1.	8.05	0.120	4.152	1.82	2.56	26.3
2.	8.28	0.165	3.499	2.18	1.91	23.7

Хөрсний хүнд металлын шинжилгээний дүнг Зураг 2-19-т тусгав.



Зураг 2-19. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

Хөрсний хүнд металлын агууламжийг 33 элемент дээр шинжлүүлсэн бөгөөд үүнээс онцгой хортой 9 элементийг MNS:5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад химийн бодисын агуулахын орчмоос авсан хөрсний цайрын агууламж стандартын хүлцэх агууламжаас 1.4 дахин их байгаа бол бусад элементүүд MNS:5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтгүй байна.

Ургамлын мониторинг. Тус агуулах нь үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд ихэнх талбай хатуу хучилттай учраас ургамшилын хэв шинжийг харгалзан үзэж 1 цэгт ургамлын геоботаникийн бичиглэлийг Браун бланкийн арга зүйд тулгуурлан хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 2-12. Ургамлын бичиглэл хийсэн байршил

№	Байршил	Өргөрөг	Уртраг
1.	Оффисын хажууд	47°53'48.20''	106°52'24.10''

2022 оны 10 дугаар сард бүртгэгдсэн ургамлын зүйлийн жагсаалтыг Хүснэгт 2-13-д тусгав.

Хүснэгт 2-13. Ургамлын жагсаалт

№	Овгийн нэр	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр
1.	Asteraceae Bercht. & J. Presl 1820	<i>Artemisia xerophytica</i> Krasch. 1922	Хуурайсаг шарилж
2.	Asteraceae Bercht. & J. Presl 1820	<i>Taraxacum dealbatum</i> Hand-Mazz. 1907	Цайвар багваахай
3.	Asteraceae Bercht. & J. Presl 1820	<i>Artemisia dracunculus</i> L. 1753	Ишгэн шарилж
4.	Plantaginaceae Juss. 1789	<i>Plantago depressa</i> Willd. 1813	Навтгар тавансалаа
5.	Urticaceae Juss. 1789	<i>Urtica cannabina</i> L. 1753	Олслиг халгай
6.	Rosaceae Juss. 1789	<i>Potentilla acaulis</i> L. 1753	Ишгүй гичгэнэ
7.	Amaranthaceae Juss. 1789	<i>Salsola collina</i> Pall. 1803	Толгодын бударгана
8.	Ranunculaceae Juss. 1789	<i>Leptopyrum fumarioides</i> (L.) Rchb. 1828	Утаахай барбад
9.	Poaceae Barnhart 1895	<i>Agropyron cristatum</i> (L.) Gaertner 1770	Саман ерхөг

Нийт 7 овгийн 9 зүйл ургамал бүртгэгдсэн.

ДҮГНЭЛТ

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь Химийн бодисын агуулахын 2022 оны БОМТ-нд тусгагдсан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Агуулахын агааржуулалтын системийг өдөр бүр тогтмол шалгаж, бүртгэл хөтөлдөг.
- Химийн бодисын сав баглаа тус бүр дээр ХАЛМ-ын дагуу тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан
- Айвико ХХК-иар ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
- МКЛ сургалтын төвтэй хамтарч химийн бодис аюулгүй ажиллагааны сургалт, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтантай хамтран ажилчдад Галын аюулгүй байдлын дадлага сургалтыг амжилттай зохион байгуулсан.
- Химийн бодис асгарах, алдагдах үед хэрэглэх саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгадаг
- Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд заасан хугацаанд тогтмол тээвэрлүүлдэг, аюултай хог хаягдлыг Цэцүүх Трейд ХХК-д хүлээлгэн өгдөг
- Мэйжор Дриллинг ХХК нь Энвайроментал Комплаинц ХХК-иар аудит хийлгэсэн бөгөөд аудитын дүгнэлтэд заасан авч хэрэгжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан бүх ажлыг хэрэгжүүлсэн.

<i>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг</i>	<i>Хийх ажлын тоо</i>	<i>Хийсэн ажлын тоо</i>	<i>Биелэлт /хувиар/</i>
<i>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт</i>	5	5	100
<i>Ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт</i>	1	1	100
<i>Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт</i>	4	4	100
<i>Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт</i>	5	5	100
<i>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт</i>	4	4	100
<i>Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт</i>	5	5	100
<i>Нийт</i>	24	24	100

Мэйжор Дриллинг Монгол ХХК нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 24 ажлыг хийж гүйцэтгэн, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр амжилттай ажилласан байна.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Хавсралтын нэр	Хуудас
1.	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	1
2.	Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулбар	2
3.	ХУД-ийн Тохижилт үйлчилгээний төвтэй байгуулсан хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ	2
4.	Цэцүүх Трейд ХХК-тай байгуулсан Тээвэрлэлтийн гэрээ	3
5.	Цэцүүх Трейд ХХК-тай байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ	5
6.	Аюултай хог хаягдлын дагалдах бичиг	3
7.	Ажлын байрны Галын аюулгүй байдлын дүгнэлт	2
8.	Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө	24
9.	Онц аваарын үед баримтлах журам	9
10.	Ногоон байгууламж хийлгэсэн төлбөрийн баримт	1
11.	Аудитын дүгнэлт	2
12.	Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, хэмжил зүйн лабораторийн хариу	1
13.	Хөрсний ерөнхий шинжилгээний хариу	1
14.	Хөрсний хүнд металлын шинжилгээний хариу	4